



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mjia.gov.mn,
http://www.mjia.gov.mn

2016.12.28 № 1-1/2266.
танай 2016.11.28 ны № 11 -Т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Г.ЗАНДАНШАТАР ТАНАА


Танаас ирүүлсэн 2016 оны 11 дүгээр сарын
28-ны өдрийн 11 тоот асуулгын хариуг үүгээр
хүргүүлж байна.

Хүлээн авна уу.

Хавсралт: 7 хуудастай.

Хувийг: Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт

САЙД



С.БЯМБАЦОГТ

Doc.said 05.2016
08 2349

2016 оны ... сарын ... өдрийн
1-1/2016
Төрийн албан бичгийн хавсралт



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ АСУУЛГЫН ХАРИУ

Нэг. Монгол Улсын хэмжээнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд тавих хяналт, өнөөгийн нөхцөл байдлын талаар:

Монгол Улс нь Мансууруулах бодисын тухай 1961 оны конвенцид 1990 онд, Сэтгэцэд нөлөөт бодисын тухай 1971 оны конвенцид 1999 онд, Мансууруулах бодис ба сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг 1988 оны конвенцид 2001 онд, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн конвенцид 2008 онд тус тус нэгдэн орсноор олон улсын өмнө тодорхой үүрэг, хариуцлага хүлээж байна.

Монгол Улсын Засгийн газрын зүгээс мансууруулах бодисын талаарх олон улсын санаачлага зорилго, зорилтыг хангах чармайлт гаргаж 2002 онд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг баталж, 2002 онд баталсан Эрүүгийн хуулиар дээрх төрлийн гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлагыг тогтоож, 2000-2005 онд хар тамхи, мансууруулах бодисын эсрэг үндэсний хөтөлбөр батлуулан хэрэгжүүлсэн.

2003 онд Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хар тамхи, мансууруулах бодис, гэмт хэргийн асуудал эрхэлсэн алба /UNODC/-ны хооронд Вена хотноо харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж, Хар тамхи, мансууралтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг шинэчлэх, Засгийн газар холбогдох байгууллага, агентлагийн чадавхийг бэхжүүлэх, сургалт явуулах, техник хамтын ажиллагааны төсөл хэрэгжүүлж хамтран ажиллахаар болсон.

Мөн 2005 онд Москва хотноо ОХУ-ын Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих Холбооны алба, Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам хамтран мансууруулах бодис тэдгээрийн түүхий эдийн хууль бус эргэлттэй тэмцэх талаар хамтран ажиллах хэлэлцээр байгуулсан бөгөөд хэлэлцээрийн хүрээнд Монгол Улс 2006 оноос эхлэн “Канал” нэгдсэн арга хэмжээнд жил бүр ажиглагчаар, 2007 оноос Хил орчмын бүс нутгийн хууль хяналтын байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах тухай нэмэлт протоколыг батлан, хамтран хэрэгжүүлж байна.

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны /UNODC/ 2011 оны тайланд ...Баруун Европ, Америкт каннабисийн, Алс болон Ойрхи дорнод, Зүүн өмнөд Азид амфетамин, синтетик төрлийн хар тамхины хэрэглээ, үйлдвэрлэгч орнууд нэмэгдэж, энэ төрлийн хар тамхины зах зээл өргөжиж байна. Хөгжиж байгаа болон буурай хөгжилтэй орны эдийн засаг, хууль эрх зүйн болон бусад сул талыг ашиглан зохион байгуулалттай гэмт бүлгүүд мансууруулах бодисын үйлдвэрлэлээ эдгээр улс уруу шилжүүлж байгаа.... тухай дурджээ.

Цагдаа, хил, гаалийн байгууллагаас ирүүлсэн мэдээллээс үзвэл БНХАУ, ОХУ болон Зүүн өмнөд азийн орноос гэсэн 3 урсгалаар амфетамин, метамфетамин төрлийн болон мансууруулах ургамлын гаралтай бодисыг Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн, нэвтрүүлэхийг завдсан, зарж борлуулсан гэмт хэрэг, зөрчил ихсэж байна. Одоогийн байдлаар БНХАУ-с ихэвчлэн амфетамин, метамфетамин төрлийн мөс /ICE/ болон мансууруулах

ургамлын гаралтай шавар /Hashish/, ОХУ-с сэтгэцэд нөлөөт анданте зэрэг эм хууль бусаар нийлүүлэгдэх болсон.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэлээр сүүлийн арван жилд /2006-2016 он/ Эрүүгийн хуулийн тусгай ангийн 188, 192-196 дугаар зүйлд заасан /мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах, улсын хил нэвтрүүлэх/ гэмт хэрэг 388 бүртгэгдэж, 1112 хүн холбогдон шалгагдсан бөгөөд дээрх бодисыг улсын хилээр нэвтрүүлэх арга, хэлбэр улам нарийсан, олон улсын шуудан илгээмж, цахилгаан бараа, ахуйн болон хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүнд нуух, бусдад дайх хэлбэрээр хууль бусаар хил нэвтрүүлэх, борлуулахдаа товлосон газарт нууж үлдээх, төлбөр тооцоог урьдчилж бусдын данс ашиглан авах, шилжүүлэх зэргээр нарийн зохион байгуулалттай үйлдэж байна.

Уг гэмт хэргийн нөхцөл байдлыг сүүлийн гурван жилээр харьцуулж харахад:

- 2014 онд гэмт хэрэг 69,4 хувь, холбогдогч 45.5 хувиар,
- 2015 онд гэмт хэрэг 29.5 хувь, холбогдогч 17.4 хувиар өссөн,
- 2016 онд гэмт хэрэг 24.0 хувиар, холбогдогч 30.7 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Насны байдлаар авч үзвэл 18 нас буюу насанд хүрээгүй холбогдогчийн тоо 2 дахин, 19-25 насны холбогдогч 24.2 хувиар, 26-35 насны холбогдогч 38 хувиар, 35-аас дээш насны холбогдогч 3.6 хувиар тус тус өсчээ.

Улсын хэмжээнд 2014 онд каннабис 13841 гр, гашиш 15,5 гр, мөс 140,8 гр, 2015 онд каннабис 9808,2 гр, гашиш 24,5 гр, мөс 344,2 гр, мансууруулах сэтгэцэд нөлөөт эм 2331 ширхэг, экстази 4 ширхэг, 2016 онд каннабис 10816 гр, гашиш 89,9 гр, кокаин 0,4 гр, мөс 626,5 гр, мансууруулах үйлчилгээтэй, сэтгэцэд нөлөөт эм 654 ширхэгийг эд мөрийн баримтаар тус тус хураан авчээ.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийг шүүхээс шийдвэрлэсэн байдлыг харахад 2014-2015, 2016 оны эхний 10 сарын байдлаар нийт 131 эрүүгийн хэргийг эцэслэн шийдвэрлэж, 189 шүүгдэгчийг гэмт буруутайд тооцон, баривчлах болон хорих ялаар шийтгэсэн байна.

Гадаад улсад 2006 оноос хойш өнөөдрийг хүртэл хугацаанд манай улсын 117 иргэн хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдон шалгагдсан бөгөөд тээвэрлэсэн 13, хадгалсан 15, хилээр нэвтрүүлсэн 41, хэрэглэсэн 39, бусдад дамжуулсан 1 иргэн тус тус тухайн орны шүүхээс ял шийтгэгдсэн бөгөөд 2016 оны эхний 10 сарын байдлаар 9 хэрэгт 9 иргэн холбогдон шалгагдаж байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг сүүлийн жилүүдэд өсч байгаа нь хэд хэдэн үндсэн хүчин зүйл нөлөөлж байна. Тухайлбал манай орны зарим нутаг дэвсгэрт мансууруулах төрлийн ургамал ургадаг, түүнийг хүүхэд, залуучууд бие биеэсээ сонсох, даган дуурайх, цахим сүлжээнд энэ төрлийн мэдээлэл хяналтгүй цацагдаж байгаатай холбоотойгоор төрөл бүрийн эх сурвалжаас буруу, ташаа мэдээлэл, үлгэр дууриал авах хандлага их байна. Жишээлбэл: тухайн бодисыг хэрэглэсэн тохиолдолд ташаал авдаг, өвчин шаналлаа мартдаг, урлагийн онгод ордог гэх мэтээр ташаа мэдээлэл их авч байна.

Хоёр. Гэмт хэрэг өссөн шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээ

Манай улсын хувьд сүүлийн жилүүдэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг жил ирэх тусам өссөн нь геополитик, нийгэм эдийн засгийн хөгжил, дэд бүтэц, хяналт шалгалт, эрх зүйн орчин, иргэдийн эрх зүйн боловсрол муу байгаа зэргээс шалтгаалж байгаагаас гадна үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх төрийн цогц ажиллагаа, нэгдсэн бодлого дутагдаж байна.

2006-2010 онд энэ төрлийн гэмт хэргийн ихэнх хувийг манай оронд ургадаг мансууруулах үйлчилгээтэй зэрлэг олсны ургамал /каннабис/-ын төрлийн бодисыг олж авах, хадгалах, борлуулах, илгээх гэмт хэрэг эзэлж байсан бол 2011 оноос химийн аргаар боловсруулсан сэтгэцэд нөлөөт бодис болох амфетамин, метамфетамин агуулсан мөс /ICE/ гэх нэршилтэй бодисын хэрэглээ, гэмт хэргийн гаралт, холбогдогчдын тоо тогтмол өсч, нас залуужиж байгаа нь гэмт хэргийн тоо бүртгэлээс харагдаж байна. Ялангуяа лабораторийн аргаар боловсруулсан, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлийг хэрэглэж байгаагаас үзэхэд уг бодисын нэр төрөл олширч, хурдан үйлчлэл бүхий мансуурах бодис хэрэглэдэг хэрэглэгч, зуучлагч, тээвэрлэгчийн давхарга, сүлжээ хэдийн бий болжээ.

Иймээс мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, хяналт тавих, энэ төрлийн бодисын хор хөнөөлөөс хүн амын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх, ажлын уялдаа холбоог сайжруулах чиглэлээр тодорхой ажлыг зохион байгуулж байна.

Тухайлбал Хууль зүйн яамны /хуучин нэрээр/ дэмжлэгтэйгээр хууль сахиулах, алба хаагчдын хэрэгцээнд БНХАУ-ын хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, алба хаагчдыг бэлтгэхэд ашигладаг сургалтын хөтөлбөрийг орчуулан хэвлүүлж холбогдох албадад, мөн мансууруулах бодис хэрэглэсэн эсэхийг шалгах тестийг төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэст тус тус олгосон.

Мөн улсын хилээр орж, гарч буй иргэдэд мэдээлэл, сэрэмжлүүлэг өгөх, урьдчилан сэргийлэх зорилгоор Цагдаа, Гааль, Татварын ерөнхий газар, Гадаадын иргэн, харъяатын газар, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв болон энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай хамтран Буянт-Ухаа, Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь хилийн боомтод "Хар тамхины эсрэг хамтдаа", "Мансууралгүй ирээдүй" өдөрлөгийг, нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагч, их, дээд сургуулийн оюутнуудад "Хар тамхи, мансууруулах бодисын хор хөнөөл" сэдвээр сургалт, 6-н төрлийн урьдчилан сэргийлэх зурагт хуудсыг тараах ажлыг тус тус зохион байгуулсан.

Гурав. Судалгааны дүн, тоон мэдээлэл, энэ чиглэлээр дагнан ажилладаг байгууллагын албан хаагчдын мэдлэг, тоног төхөөрөмжийг хэрхэн сайжруулах, цаашид авах арга хэмжээний талаар:

Дэлхий нийтэд нийгэм, эдийн засгийн өөрчлөлтөөс шалтгаалан гэмт хэргийн бүтэц байнга өөрчлөгдөж, их хэмжээний хууль бус орлого олох зорилгоор хүн худалдаалах, мансууруулах бодис наймаалах, нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодисын хууль бус эргэлт, терроризм, түүх соёлын дурсгалт зүйлсийн хууль бус эргэлт, хууль бус цагаачлал, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл байгуулах гэмт

хэргүүд байнгын шинжтэй үйлдэгдэх болсон ба түүний санхүүгийн эх үүсвэрийг хар тамхи, мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтээс олж буй бохир мөнгө бүрдүүлж байна.

Ийм учраас үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах үүднээс хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг төр, иргэний нийгмийн уялдааг хангасан урт хугацааны бодлого боловсруулан хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах нь тулгамдсан асуудлын нэг болоод байна.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 07 дугаар сарын 15-ны өдөр баталсан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд иргэдийг терроризм, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, хүчирхийллээс хамгаалах нөхцөлийг сайжруулах, хүүхэд, эмэгтэйчүүд, иргэдийг хүн худалдах гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоохтой холбогдсон эрх зүйн орчныг боловсронгуй болгох, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус хэрэглээтэй тэмцэх үндэсний чадавхийг бэхжүүлэх, урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг эрчимжүүлж, олон улсын хамтын ажиллагааг идэвхжүүлхээр тус тус заасан.

2002 онд баталсан Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулиар уг бодисын эргэлтэд хяналт тавих, хүн амын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулж, хууль бус эргэлттэй холбогдсон асуудлыг гэмт хэрэгт тооцон Эрүүгийн хуулийн тусгай ангийн 188, 192-196 дугаар зүйлд зааснаар зохицуулж, хариуцлага тооцож байгаа ч хар тамхи, мансууруулах эм болон сэтгэцэд нөлөөт бодисыг боловсруулах, зарж борлуулах, тээвэрлэхтэй холбоотой гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, өсөлт, чиг хандлага, эдгээр бодисын хууль бус хэрэглээг бүрэн хянах нийгмийн хэрэгцээ, шаардлагыг хангахгүй байна.

Тиймээс Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг, мөн хууль бус эргэлттэй тэмцэх Үндэсний хөтөлбөрийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг тус тус байгуулан ажиллаж байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн гол зорилго нь иргэдийг дээрх төрлийн бодисын хор хөнөөл, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг таслан зогсоох, илрүүлэх ажлыг нэгдсэн бодлого, удирдлага, зохион байгуулалтаар хангах явдал юм.

Хөтөлбөрийг үндсэн 5 зорилтын хүрээнд 2017-2019, 2019-2021 он хүртэл 2 үе шаттайгаар хэрэгжүүлхээр төлөвлөлөө. Тухайлбал:

- Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэхэд төрөөс баримтлах бодлого, эрх зүйн орчныг боловсронгуй болгох,
- Төрийн байгууллагуудыг нэгдсэн бодлого, удирдлага, зохион байгуулалтаар хангах ажлыг оновчтой зохион байгуулах,
- Иргэдийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ авах,
- Уг бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг судлах, тэдгээрийг арилгах арга замыг оновчтой тодорхойлох,

- Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий хууль сахиулах, шүүх эрх мэдлийн болон эрүүл мэндийн байгууллагын алба хаагч, ажилтныг мэргэшүүлэх, орчин үеийн шинэ техник, технологи нэвтрүүлэх зорилтыг тус тус тусгасан.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тухай бүр тусган санхүүжүүлэх ба олон улсын байгууллагын хандив тусламж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн нөөц бололцоог ашиглах, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх Үндэсний хороо, аймаг, нийслэлийн салбар хорооны дэргэд сан байгуулах замаар хэрэгжүүлхээр төлөвлөж байна.

Дээрх эрх зүйн баримт бичгийг батлан хэрэгжүүлснээр хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээ түүнд тавих хяналт, хууль бус эргэлт, хэрэглээтэй тэмцэх, таслан зогсоох, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлан тогтоох замаар урьдчилан сэргийлэх, хэрэглэсэн, донтсон этгээдийг сайн дурын болон албадан эмчлэх, тусламж үйлчилгээ үзүүлэх нэгдсэн тогтолцоо бий болж, төрийн бодлого цогц байдлаар, уялдаа холбоотой хэрэгжих нөхцөл бүрдэх юм.

Монгол Улсын хувьд хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх, шинжилгээ судалгаа хийх тоног төхөөрөмжийн хангалт, шинэчлэл дутагдалтай, өсвөр насны хүүхэд залуусыг урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, хэрэглэгч болсон, донтсон тохиолдолд үзүүлэх анхан шатны эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх стандарт байхгүй, мэргэжилтэн боловсон хүчнийг бэлтгэх, чадваржуулах нэгдсэн тогтолцоо хангалтгүй байгаагаас энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд хүндрэл учирч байна.

Өнөөдрийн байдлаар мэргэжилтэн, боловсон хүчнийг Хууль сахиулахын их сургуулийн бакалаврын сургалтаар бэлтгэж байгаа бөгөөд 2015 онд Эрүүгийн цагдаагийн газрын бүтэц, орон тоог өөрчлөн баталж, тус газарт Хар тамхитай тэмцэх хэлтсийг дарга 1, тасгийн дарга 2, ахлах төлөөлөгч 8, төлөөлөгч 4, ахлах мөрдөн байцаагч 3, мөрдөн байцаагч 2 нийт 20 орон тоотойгоор хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллаж байна. Дээрх алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр ЦЕГ-ын сургалт дадлагын төвд сургалт зохион байгуулахын зэрэгцээ гадаад улс орнуудаас мэргэжилтэн урьж алба хаагчдыг мэргэшүүлэх, Тайланд, Арабын Бүгд Найрамдах Египет улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Шинжян Уйгур, ӨМӨЗО, Филиппин, Бүгд Найрамдах Солонгос Улс, Япон зэрэг улс оронд алба хаагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулах ажлыг тус тус зохион байгуулж байна.

Цагдаагийн байгууллагын албан хэрэгцээнд АНУ-д үйлдвэрлэсэн, хар тамхи, мансууруулах бодис шээснээс илрүүлэгч тест, богино хугацаанд танигч TRUNARC маркийн багажийг ашиглаж байгаа ч, сүүлийн үеийн лабораторийн аргаар боловсруулсан мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлийг илрүүлэхэд техник, технологийн хувьд шаардлага хангахгүй байна.

Мөн Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд хар тамхи, мансууруулах бодис шинжлэх химийн лаборатори ажиллаж байгаа бөгөөд уг лаборатори нь эрхлэгч-1, ахлах шинжээч-2, шинжээч-2, лаборант-1 орон тоотойгоор хууль сахиулах байгууллагаас ирүүлсэн гэмт хэргийн эд мөрийн баримтаар хураагдсан байгалийн болон нийлэг гаралтай мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисод шинжилгээ хийж, холбогдох дүгнэлтийг гаргаж байна. Харин хүний биологийн материал болох үс, цус, шээс, хумсанд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис тодорхойлох шинжилгээг хийх техникийн боломжгүй бөгөөд зориулалтын /HPLC-MS/ багаж, тоног төхөөрөмж шаардлагатай байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторид зөвхөн эмийн бүтээгдэхүүнд шинжилгээ хийдэг бөгөөд 25 шинжээч, Улаанбаатар хот, 21 аймаг, хилийн 3 боомтод эм биобэлдмэлийн хяналтын 39 улсын байцаагч үүрэг гүйцэтгэж байна.

Гаалийн ерөнхий газар нь дэлхийн гаалийн байгууллагын гишүүн орны хувьд мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэх зорилгоор бүс нутгийн хамтарсан ажиллагаанд тогтмол оролцох, холбогдох байгууллагатай хэрэг, зөрчлийн мэдээлэл солилцох, хамтран ажиллах хэлбэрээр хэд хэдэн арга хэмжээг хэрэгжүүлж байна. Ялангуяа шинэ төрлийн сэтгэцэд нөлөөт бодис (New Psychotropic Substances буюу NPS)-ын хууль бус эргэлт, хэрэглээ дэлхийн олон улс оронд хурдацтай нэмэгдэж, нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдалд ноцтой заналхийлж байгаатай холбоотойгоор Дэлхийн гаалийн байгууллагаас хэрэгжүүлж буй SmartCat2 ажиллагаанд Монголын гаалийн байгууллага үндэсний холбоо баригч томилон оролцох болсон.

Мөн агаараар улсын хил нэвтэрч буй зорчигч, шуудан илгээмж, ачаа тээшийн мэдээллийг онгоц буухаас 2 цагийн өмнө урьдчилан авах замаар эрсдэлтэй, сэжиг бүхий зорчигчдыг сонгон хяналт шалгалт хийх, Буянт-Ухаа, Замын-Үүдийн гаалийн газарт хүний биеийн хэт авиа, дүрс оншлогооны багажаар тоноглож, бусад боомтод рентген аппаратаар болон албаны 40 гаруй эрэлч нохойгоор хяналт тавих ажлыг зохион тус тус зохион байгуулж байна.

Тус байгууллагад хяналт шалгалтаар илэрсэн сэжиг бүхий бодисыг нарийвчлан шинжлэх 2 лаборатори ажиллаж байгаа хэдий ч хар тамхи илрүүлэх зориулалт бүхий /Sabre-5000/ 3 ширхэг аппарат үйлчилгээний зардалгүйгээс ашиглах боломжгүй байна.

Монгол Улсын хэмжээнд хар тамхи, мансууруулах бодис хэрэглэгчдэд чиглэсэн нэгдсэн тандалт судалгааг 2010 онд Нийслэлийн эрүүл мэндийн газар, Глобаль сан хамтарч, 2011 онд Хууль зүй, дотоод хэргийн яам, "Дэлхийн зөн" олон улсын байгууллагын хамтарч тус тус судалгаа хийж байсан. Уг судалгаагаар 74000 - 90.000 хэрэглэгч байна гэсэн зөрүүтэй тоон мэдээ гарсан нь судалгааны зорилго, арга зүй, шалгуур үзүүлэлт, нөхцөл байдлын зөрүүтэй тайлан, мэдээ зэргээс шалтгаалж өөр өөр судалгааны дүн гарчээ.

Иймээс дээрх судалгааг бодитой болгох, судалгааны нэгдсэн аргачлал, шалгуур үзүүлэлтээр судалгааны мэргэшсэн байгууллагаар хийлгэх шаардлагатай гэж үзэж байгаа бөгөөд бэлтгэл ажлын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яамны дэмжлэгтэйгээр Цагдаагийн байгууллагаас улсын хэмжээнд "БҮРТГЭЛ-2016" нэгдсэн арга хэмжээг зохион явуулж байна.

Дөрөв. Манай оронд ургаж буй мансууруулах төрлийн үйлчилгээтэй ургамлын тархац, устгал, түүнд шаардагдах зардлын талаар.

Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны санхүүжилтээр 2014 онд Цагдаагийн ерөнхий газар, Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газар, Шинжлэх ухааны академийн Ботаникийн хүрээлэнгийн хамтарсан судалгаагаар мансууруулах болон донтуулах үйлчилгээтэй бодис бүхий ургамал болох намуу, зэрлэг олс, зээргэнэ, лантанз зэрэг 9 овог, 11 төрөлд хамаарах 18 зүйл ургамал нь манай улсын 14 аймгийн 49 гаруй сумын нутаг дэвсгэрт 15,000 орчим га талбайд ургадаг гэсэн тооцоог гарсан байна.

2013 онд Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны /хуучин нэрээр/ Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас мансууруулах, донтуулах үйлчилгээтэй бодис бүхий

ургамлыг устгахад 1 га талбайд гарах зардлыг механик аргаар 53,300 төгрөг, химийн аргаар 40,300 төгрөг байхаар тус тус тооцон гаргажээ.

Энэ төрлийн ургамал нь нэг наст ургамлын төрөлд багтдаг бөгөөд энэхүү ургамлыг үрээ цацахаас өмнө буюу 5, 6 дугаар сард 3 жил дараалан устгавал бүрэн устгах боломжтой гэсэн мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн мансууруулах болон донтуулах үйлчилгээ бүхий ургамлыг түүж бэлтгэх эрсдэлтэй 500 орчим га талбайг сонгон авч 2013 онд орон нутгийн цагдаагийн газрын хөрөнгөөр, 2014, 2015 онд Хууль зүйн яамны /хуучин нэрээр/ дэмжлэгтэйгээр устгах арга хэмжээг зохион явуулснаар талбайн хэмжээ 157 га орчим болон багассан, зарим газарт устаж үгүй болсон, тархац багасаж, сийрэгжсэн үр дүн тус тус гарсан.

ДҮГНЭЛТ

Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдогч нь амар хялбар аргаар хөрөнгөжих зорилгоор энэ төрлийн гэмт хэргийг үйлдэж байгаа нь гэмт хэргийн тоо өсөх, хөдөө, орон нутагт мансууруулах үйлчилгээтэй зэрлэг олсны ургамлын тархац их, мөн хот суурингийн ойр орчим, авто болон төмөр зам дагуу ихээр ургаж байгаа нь залуучууд түүж бэлтгэх, хэрэглэх нөхцөлийг тус тус бүрдүүлж байна.

Иймээс олон улсад энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа сайн туршлагыг судлах, нэвтрүүлэх, алба хаагчдыг чадавхжуулах, гадаад улсад сургах, нарийн мэргэшүүлэх, шаардлагатай орчин үеийн техник, багаж хэрэгслээр хангах, хэрэглэгч, донтогчдыг эмчлэх, туслалцаа үзүүлэх, эмчилгээний арга зүй, стандарттай болох, мэргэшсэн эмч ажилтан бэлтгэх, зориулалтын наркологийн төвийг байгуулах асуудлыг яаралтай шийдвэрлэх шаардлагатай байна.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ